



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 81446

Номгон

Г Иргэн Б.Давгабазарын эзэмшил газрын Г
зөрчил арилгах тухай

Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолын 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Иргэн Б.Давгабазарын (BA59011919) Дэд бүтцийн байгууллагын зориулалттай 3710 м2 газрын талбайн хэмжээ зөрүүтэй байгаа тул илүү эзэмшиж буй 200 м2 газарт дуудлага худалдааны анхны үнэ дээр дуудах нэг удаагийн интервалыг 2 дахин өсгөн нөхөн төлбөр төлүүлж, нэмж эзэмшүүлэн газрыг хавсралтаар баталсугай.

2.Газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн “Э” дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхыг иргэн Б.Давгабазарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210035



Аймгийн Засаг дарга 2022 оны 07 дугаар сарын
09-ний өдрийн А/446 дугаар захирамжийн хавсралт

ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТАЛБAYН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДӨЖ
БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ

д/д	Газар эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Хаяг	Талбайн хэмжээ /м2/	Залруулгаар нэмэгдэж байгаа талбайн хэмжээ /м2/	Нийт талбайн хэмжээ
1	Б.Давгабазар	BA59011919	6409008640	Дэд бүтцийн байгууллага	Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Байдрагийн гудамж-1, 101 тоот	3710 м2	200 м2	3910 м2

-----oOo-----